



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар A/420

Мөрөн сүм

Ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аялал жуулчлалын улирлыг утгаж аймгийн хэмжээнд нийтийн эдэлбэр газар, улсын чанартай авто зам, голын хамгаалалтын бүс орчмын хог хаягдлын цэвэрлэгээ болон нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хашаа, хайсны өнгө үзэмжийг сэргээж хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.
2. Хог хаягдлыг цэвэрлэх ажлын ерөнхий удирдамжийг нэгдүгээр, тайлан ирүүлэх хүснэгтийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус, тус баталсугай.
3. Аймгийн хэмжээнд нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлын хүрээнд сумдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж, холбогдох тайланг нэгтгэн аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.
4. Хог хаягдлыг цэвэрлэх ажлыг сум бүр үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээг 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн дотор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН



Аймгийн Засаг даргын 2022 оны
04 дүгээр сарын 21-ний өдрийн А/72-
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ АЖЛЫН
УДИРДАМЖ



Зорилго. Хог хаягдлын тухай хуулийн 9.4.3, 9.4.5, 9.4.6-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, төв суурин газрын ойр орчимд үүссэн хогийг цэвэрлэхэд бүх нийтийг татан оролцуулах, Хог хаягдлын тухай хуулийг сурталчлах, Байгальд хог хаяхгүй байх, эх үүсвэр дээр нь ангилан ялгах уриалгыг хүргэх, иргэдийн хандлагыг өөрчлөхөд оршино.

Хугацаа: 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс 05 дугаар сарын 02

Зохион байгуулагч: Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сумдын Засаг даргын Тамгын газар

Хамрах хүрээ: Аймгийн төрийн болон орон нутгийн өмчийт аж ахуйн нэгж, албан байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газар, иргэд, аж ахуйн нэгж байгууллага оролцоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Төв суурин газрын нийтийн эдэлбэр газар, гол горхи, булаг шандны ойролцоо газар, улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу /замын 2 талруу 50 м доторх/, айл өрх, албан байгууллагууд өөрийн эзэмшлийн болон ойр орчмын гудамж талбайн хог хаягдлыг цэвэрлэх;
- Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж бүхий талбай, сад, цэцэрлэгт хүрээлэнгийн хогийг цэвэрлэх, хашаа, хайсны өнгө үзэмжийг сайжруулах, засах, угааж цэвэрлэх;
- Хог хаягдлын тухай хуулийг сурталчлах, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах нелөөллийн ажил зохион байгуулах;
- Цэвэрлэсэн хогийг тухайн сумын хог тээврийн машин явж ачин хогийн цэгт хүргэнэ. Хог хаягдлыг шатаахыг хориглоно.
- Цэвэрлэсэн хогноос хуванцар сав, шил, лаазыг ангилан ялгаж, дахивар нөөц хүлээн авах цэгт тушаах ажлыг зохион байгуулах
- Сумдын Засаг даргын Тамгын газар зам дагуух хуваарийг зургаар харуулж, хуваарилсны дагуу холбогдох байгууллагууд цэвэрлэж хүлээлгэн өгнө.

Тайлан мэдээ ирүүлэх: Сумын хэмжээнд хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээг 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн дотор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хавсралт 2-ын дагуу болон бичгээр ирүүлнэ.

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүн, сумдын оролцоо, тайлан мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
04 дугээр сарын 21-ний өдрийн АЧЧ
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

БҮХ НИЙТИЙН ЦВЭРЛЭГЭЭНИЙ ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ЗАГВАР ХУСНЭГТ

№	Сумын нэр	Hint labapnacan xor, /TH/ Targan xamkaa /ra/ Labapnacan xor xaralpnih xamkaa /TH/ Targan xamkaa /ra/ Samphir ypt Xyabaliap /TH/ Jraas /TH/ Ulin /TH/ BycaA /TH/ Mprah Tepnih surgah xara Цвэрлэгээд Хог AAB	Oporichon texhnik xeparcinii Too /lumpexer/ Cyprart cyptanumraabi aksuu Xinchash tarap
1			
2			
3			
4			
5			
6			
7			
8			
9			
10			
11			
12			
13			
14			
...			